



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 17/07

Чингис хот

Эрчим хүчний хамгаалалтын зурвас
тогтоож, баталгаажуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Засгийн газрын “Дүрэм батлах тухай” 2001 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 263 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 2.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3 дугаар багт /Баянмөнх/ байршилтай цахилгаан эрчим хүчний 110/35/6/ кв станцын хамгаалалтын зурвасын хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Цахилгаан эрчим хүчний хамгаалалтын зурвасын хэмжээг мөрдөн ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч /Ц.Идэрбат/-д, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/-д тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



231010007

Аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 14-ний
өдрийн А/07 дүгээр Захирамжийн хавсралт



Хамгаалалтын зурвас

